

ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙД ХЯНАН БАТАЛГАА ХИЙХ,
ХЯНАН БАТЛАГЧИЙГ СУРГАХ, МЭРГЭШЛИЙН ҮНЭМЛЭХ
ОЛГОХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Иргэн аж ахуйн нэгж, байгууллага нь үрийн тариалангийн талбайдаа хянан баталгаа хийлгэж, улсын үрийн нөөцөд нийлүүлэх, бусдад борлуулах, өөрсдөө нөөцлөх үрийн чанар хэрэгцээг баталгаажуулах нөөц бүрдүүлэх, ахлах хянан батлагч, хянан батлагч нарт үнэмлэх тэмдэг олгох, хэрэглэхэд холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Монгол Улсын Таримал ургамлын үр, сортын тухай хуульд заасны дагуу таримлын үр үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэд, байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, хуулиар эрх олгогдсон үрийн тариалангийн талбайн хянан батлагч нар энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Хянан батлагч гэдэг нь: Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагийн үрийн зориулалтаар таримал тарьсан талбайд хянан баталгаа хийх төрийн захиргааны төв байгууллагаас олгосон үнэмлэх, тамга, тэмдэгтэй дээд боловсролтой, агрономич болон ургамал хамгааллын мэргэжилтэй байна.

1.4. Хянан батлагчийн үнэмлэх, тэмдэг нь тухайн албан тушаалтаны өмч байна.

1.5. Хянан батлагчийн үнэмлэх, тэмдгийн дугаар нь аймгийн код, сумын код, хувийн дугаараас бүрдэнэ. Хянан батлагчийн үнэмлэх, тэмдгийн дугаар ижил байна. Хянан батлагчийн тэмдгийн дугаарыг давхардуулж олгохгүй.

1.6. Хянан батлагчийн үнэмлэх, тэмдгийн бүртгэлийг тухай бүр шинэчилж байна.

Хоёр. Үрийн тариалангийн талбайн үрийн сортын хянан баталгаа хийх зарчим, зорилго хамрах хүрээ

2.1. Үрийн тариалангийн хянан баталгаа нь үрэнд зориулсан талбайгаас мэргэжлийн байгууллага, мэргэшсэн хянан батлагч нар дээж авч, зааврын дагуу үнэлгээ өгч, сортын цэвэр байдлыг хянаж баталгаажуулах үйл ажиллагааны зарчимд тулгуурлана.

2.2. Үрийн тариалангийн талбайд хянан баталгаа хийх зорилго нь тариалан эрхэлдэг бүхий л байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийн дараа жилд тариалах талбайг сортын үндсэн шинж чанарын улсын стандартын шаардлага хангасан, нутагшсан, ирээдүйтэй сортын үрээр хангах, талбайн ургацыг баталгаажуулахад оршино.

2.3. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийх нь үр үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг бүрэн хамарсан байвал зохино.

Гурав. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийх, зохион байгуулах нэгж, ажилтан, түүний эрх, үүрэг

3.1. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийх ахлах хянах батлагч, хянан батлагч нарын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тухайн орон нутгийн тариалангийн үйлдвэрлэл эрхэлсэн нутгийн захиргааны байгууллага холбогдох төрийн байгууллагуудаас, санал авч батална

3.2. Үр тарианы үйлдвэрлэл эрхэлж буй 100 га ба түүнээс дээш хэмжээтэй талбайд, төмс, хүнсний ногоо тариалж буй 10 га ба түүнээс дээш хэмжээтэй талбайд тус тус 3-аас доошгүй хянан батлагчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан баталгаа хийнэ.

3.3. Тариалангийн бүс нутгуудад хянан батлагч нар хүрэлцэхгүй тохиолдолд тухайн орон нутгийн /сумдын/ агрономич, үрийн аж ахуйн агрономич, ургамал хамгааллын мэргэжилтнүүдийг татан оролцуулж болно.

3.4. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийх эрх бүхий этгээд нь Мэргэжлийн хяналтын байгууллагын хянан батлагчийн үнэмлэх, тэмдэгтэй Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналт, Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын /ахлах/ байцаагч, төрийн захиргааны агрономич, ургамал хамгааллын мэргэжилтэн байна.

3.5. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийх хянан батлагч нь Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны даргын 2001 оны 07 дугаар сарын 16-ны 40 дүгээр тушаалаар батлагдсан зааврын дагуу талбайгаас дээж авч, нэг бүрчлэн задлан шинжилгээ хийж, хянан баталгааны акт, бусад баримтыг үнэн зөв бүрдүүлэн, хянан баталгааны дүн, үнэлэлт дүгнэлтийг ургац хураалтаас өмнө тогтоосон хугацаанд /Тухайн жилийн 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор/ Мэргэжлийн хяналтын төв байгууллага болон Тариалангийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.6. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийх хянан батлагч нар нь тухайн сортын гарал үүслийг сайтар шалгаж акт үйлдэнэ.

3.7. Хянан батлагч нар нь үрийн тариалангийн таримлын ялгахад төвөгтэй таримал болон хог ургамлаар бохирдсон гадаад, дотоод хорио цээртэй хог ургамал болон өвчин хортонд нэрвэгдсэн байдлыг тогтоон аж ахуйн зүгээс үрийн аж ахуйн ажлын явцыг хэрхэн хөтөлснийг шалгаж үнэлэлт дүгнэлт өгнө.

3.8. Үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийсэн акт нь түүнийг баталгаажуулах эрх бүхий этгээд /Ахлах хянан батлагч/ гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

3.9. Гарал үүсэл нь тодорхойгүй, талбайн түүх хөтлөөгүй аж ахуйн нэгж, иргэд, байгууллагын тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийж акт үйлдэхгүй.

Дөрөв. Үрийн тариалангийн талбайн сортын хянан баталгаа хийх хянан батлагч нарыг сургах, мэргэшлийн үнэмлэх, тэмдэг олгох

4.1. Үрийн тариалангийн талбайн хянан батлагч нарыг газар тариалангийн үйлдвэрлэл хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шийдвэр гаргаж 7-14 хоногийн хугацаатай мэргэшлийн сургалтанд хамруулна.

4.2. Хянан батлагчийн сургалтын зохион байгуулалт, зардлыг газар тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрэн хариуцна.

4.3. Хянан батлагчийн сургалтанд хамрагдсан суралцагчдад мэргэшлийн үнэмлэх олгоно.

4.4. Мэргэшлийн үнэмлэхний хүчинтэй хугацаа 5 жил байна.

Тав. Үрийн тариалангийн талбайн сортын хянан баталгаа хийх хянан батлагч нарын үйл ажиллагааны санхүүжилт

5.1. Тариалангийн талбайдаа хянан баталгаа хийлгэж буй аж ахуйн нэгж, иргэд, байгууллага нь хянан баталгаа хийлгэсний зардлыг бүрэн хариуцна.

5.1.1.Тариалангийн талбайд хянан баталгаа хийх зардалд талбайн хэмжээ /га/, шатахууны зардал багтана.

5.1.2.Тариалангийн талбайн хянан баталгаа хийх 1 га талбайн зардал үр тарианы талбайд 3000 төгрөгөөс дээшгүй, төмс, хүнсний ногооны талбайд 5000 төгрөгөөс дээшгүй байна.

Зургаа. Тариалангийн талбайдаа сортын хянан баталгаа хийлгэсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагийн үүрэг

6.1. Тариалангийн талбайдаа сортын хянан баталгаа хийлгэх хүсэлтээ тухайн орон нутгийнхаа газар тариалангийн асуудал хариуцсан төв байгууллагад гаргана.

6.2. Тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийлгэхэд гарах зардлыг энэхүү журмын 5.1, 5.2, 5.3-д заасны дагуу хариуцна.

6.3. Үрийн чанарыг сайжруулах талаар хянан батлагчийн хугацаатай өгсөн зөвлөгөө, даалгаврыг хугацаанд нь, бүрэн биелүүлнэ.

6.4. Хянан батлагчийн талбайгаас бүрдүүлсэн таримлын багц, дээж /сноп/-ийг актад дурьдсан хугацаагаар чанар байдлыг алдагдуулалгүйгээр хадгална.

6.5. Үрийн зориулалтаар тариалсан бүх талбайдаа хянан баталгаа хийлгэнэ.

6.6. Хянан баталгаа хийлгэж талбайн ургац нь үрэнд тэнцсэн нөхцөлд үр үйлдвэрлэгч үрээ борлуулах эрхтэй болно.

Долоо. Хариуцлага

7.1. Сортын хянан баталгаа хийх үеийн үйл ажиллагааг хянах, шалгах, хянан батлагчийн акт, дүгнэлт болон үрэнд тэнцсэн талбайн ургацыг үйлдсэн актын дагуу зохих зориулалтаар ашиглаж байгаа эсэхийг Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтын улсын байцаагч хянаж, гэм буруутай этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага оногдуулна.

7.2. Тариалангийн талбайн үрийн сортын чанарын талаар гарсан маргааныг Мэргэжлийн хяналтын төв байгууллагын Таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтын улсын ахлах байцаагч хянан шийдвэрлэнэ.